УДК 294.3
DOI 10.30792/2949-5768-2024-9-132-141

Oyunkhand Demchigmaa Borjigon

A COMPARATIVE STUDY OF TREATISE ON FIRE WRITTEN BY TIBETAN AND MONGOLIAN LAMAS

This article presents a comparative study of the Treatises on Fire written by the Mongolian scholar Lama Yeshe Tendzin Wangyal and the Tibetan scholar Lama Nomchi Khenpo Ngawang Phuntsok. Yeshe Tendzin Wangyal did not indicate the date of writing the Treatise on Fire in the colophon, but it must have been written between 1880 and 1907. The poem is rhymed in four lines, the first two describing the nature of the world, and the last two expressing the nature of «fire» and its various manifestations. The treatise consists of several sections: the first stanzas are a prayer poem; the second expresses a request for a blessing by touch; the third speaks of writing the teaching, and so on. The text consists of twelve parts, or 108 stanzas, divided into nine stanzas, plus two concluding stanzas, for a total of 113 stanzas and a colophon. The author, Yeshe Tenzin Wangyal, described the nature of the world as fire and compared it to many characteristics and functions. Overall, it is a teaching to the public that «the human body may be difficult to find, so in this age, realize the nature of the universe, worship a good teacher, meditate on sutras and mantras, study science and the universe instead of being attracted to the birth house, overcome greed, emphasize the path of enlightenment, beware of fortune and fate, try to escape from this mortal universe and achieve nirvana». Nomchi Khenpo Ngawang Phuntsok did not divide his work into separate parts. It is a poem with one verse of prayer, 67 verses of main content, two verses of blessing, a total of 70 verses, and a colophon. He mentioned in the colophon that the poem was written in the year of the Earth Rabbit (1939). Fire and fire-related things, usually the lighting of a lamp, were written in the first two lines, while the nature of the world, the characters and the content of the Buddhist teachings were in the last two lines of the four-line stanza. Along with the sermon, he briefly and clearly described and illustrated the nature of «light» – its positive property of illuminating any phenomenon and spreading well-being to all. In general, the poem teaches the need to follow the Buddhist teachings and perform virtuous deeds.

Keywords: Tibetan literature, treatises, Tibetan scholar, Mongolian scholar, treatise on the fire.

Оюунханд Демчигмаа Борджигон

СРАВНИТЕЛЬНОЕ ИССЛЕДОВАНИЕ ТРАКТАТОВ ОБ ОГНЕ, НАПИСАННЫХ ТИБЕТСКИМИ И МОНГОЛЬСКИМИ ЛАМАМИ

В статье представлено сравнительное исследование «Трактатов об огне», написанных монгольским ученым ламой Еше Тендзином Вангьялом и тибетским ученым ламой Номчи кхенпо Нгаванг Пунцоком. Еше Тендзин Вангьял не указал в колофоне дату написания «Трактата об огне», но он должен быть написан примерно между 1880 и 1907 гг. Стихотворение рифмовано четырьмя строками, первые две описывают природу мира, а последние две

Оюунханд Дэмчигмаа Боржигон – доктор филологических наук, доцент кафедры монгольского языка и языкознания, факультет искусств и наук Национального университета Монголии (г. Улан-Батор, Монголия). E-mail: demchigmaa@num.edu.mn.

выражают природу «огня» и его различные проявления. Трактат состоит из нескольких разделов: первые строфы представляют собой молитвенное стихотворение; вторые – выражает просьбу о благословении прикосновением; третьи говорят о написании учения и так далее. Текст состоит из двенадцати частей, или 108 строф, разделенных на девять строф, плюс две строфы заключения, итого 113 строф и колофон.

Автор, Еше Тендзин Вангьял, описал природу мира как огонь и сравнил его со многими характеристиками и функциями. В целом, это учение для общественности о том, что «человеческое тело может быть трудно найти, поэтому в этот век осознайте природу вселенной, поклоняйтесь хорошему учителю, медитируйте на сутрах и мантрах, изучайте науку и вселенную вместо того, чтобы притягиваться к дому рождения, преодолевайте жадность, подчеркивайте путь просветления, остерегайтесь удачи и судьбы, пытайтесь вырваться из этой смертной вселенной и достичь нирваны».

Номчи кхенпо Нгаванг Пунцок не разделил свою работу на отдельные части. Это поэма с одной строфой молитвы, 67 строфами основного содержания, двумя строфами благословения, всего 70 строф, и колофоном. Он упомянул в колофоне, что поэма была написана в год земляного Кролика (1939 г.). Огонь и связанные с огнем вещи, как правило возжигание лампады, были написаны в первых двух строках, в то время как природа мира, персонажи и содержание буддийского учения находятся в последних двух строках из четырех строк строфы. Наряду с проповедью, он кратко и ясно описал и проиллюстрировал природу «света» – его положительное свойство освещать любое явление и распространять благоденствие всем. В целом, поэма учит о необходимости следования буддийскому учению и совершении добродетельных поступков.

Ключевые слова: тибетская литература, дидактический трактат, тибетский ученый, монгольский ученый, трактат об огне.

Оюунханд Демчигмаа Борджигон

ТӨВӨД МОНГОЛ ЭРДЭМТЭН ЛАМ НАРЫН ТУУРВИСАН ГАЛЫН ШАСТИРЫГ ХАРЬЦУУЛАН АЖИГЛАХ НЬ

Энэтхэг, Төвөд, Монгол гурван улс эртнээс ном соёлын өргөн хэлхээ холбоотой явж ирсэн билээ. Ялангуяа уран зохиол, түүний дотроос сургаалын зохиолууд үүнд голлох байр эзэлнэ. Эртний Энэтхэгийн вед шастираас эхтэй иргэний яруу найраг Төвөдөд Ганжуур, Данжууураар уламжлан сургаалын зохиолын уг үндэс болсон бөгөөд улмаар Монгол сургаалын зохиолд ч үлэмжхэн нөлөө үзүүлсэн ажээ.

Монголд XVI зууны сүүл XVII зууны эхнээс шарын шашин хүчтэй дэлгэрч, тэр үеийн шашны боловсролтон лам нарын ихэнх нь үндэсний бичиг үсэг, соёл боловсролын хүрээнээс тасарсан хийгээд бурхны шашны ном зохиолыг орчуулж олон хувиар хэвлэн нийтлэхийн зэрэгцээ Энэтхэг, Төвөдийн эрдэмтэн лам нарын зохиол бүтээлийг дуурайсан маягтай шүлэг сургаалыг монгол лам нараас төвөд хэлээр зохиох нь олонтоо болж ирсэн. Үүнээс дурдвал, Зая бандид Лувсанпринлэйн «Хос ёсны сургаал», «Алтан хатгуур», Сүмбэ хамба Ишбалжирын «Хөхөөн эгшиг дуун», Цахар гэвш Лувсанцүлтэмийн «Архины хор холбогдлыг үзүүлсэн сургаал», Дандар лхаарамбын «Хүн, номын баярхурим» зэрэг олон арван зохиолыг нэрлэж болно [Цэрэнсодном 1987: 273].

XV–XVII зууны үед Төвөдөд Сажа бандид Гунгаажалцаны «Субашид» тэргүүтнийг дуурайлгасан олон сургаал гарсан ба улмаар цаашид ч ихээхэн дэлгэрч

Төвөдийн бараг бүх зохиолчийг хамарсан байна. XVII-XIX зуунд энэхүү хос ёсны чиглэлээр Жанжаа Агваанчойдонгийн «Хоёр ёсны сургаал машид тодорхой», «Хоёр ёсны авах орхихыг тодруулагч сургаал энхрийлэх арван найм», Жанжаа Ролбийдоржийн «Хоёр ёсны сургаал авах огоорохыг машид тодруулагч», Ишжалцангийн «Хос ёсны авах гээхийг тодорхой үзүүлэгч сургаал зэндмэнийн эрих» тэргүүтэн «хос ёсны сургаал» нэртэй хэсэг сургаал гарснаас гадна Гүнтэн Гончигдамбидонмэгийн «Модны шастир хоёр ёсны зуун мөчирт», «Усны шастир хоёр ёсны зуун давалгаасын эрих» гэх мэтчилэн хоёр ёсны шастир гэдэг ерөнхий нэрийн дор олон сургаал зохиогджээ [Хүрэлбаатар 1987: 209–210].

Энэтхэг, Төвөдийн Буддын утга зохиолд нэвтэрсэн дорно дахины гүн ухааны үзлээр сав шим ертөнцийг мод, шороо, гал, ус, хий таван махбодоос бүтнэ гэж үздэг. Энэ үзэл санааны дагуу Төвөд, Монголын утга зохиолд Гүнтэн гэгээн Гончигдамбидонмэгийн эхлэн үүсгэсэн «Модны шастир», «Усны шастир»-аас уламжлан Төвөд, Монголын эрдэмтэн лам нар одон болон хар зурхайн махбодууд төдийгүй эрдэнэ, тэнгэрийн эрихэс болох нар, сарны шастир хүртэл туурвижээ. Дурдвал, Төвөдийн 9 дүгээр банчин Чойжинямын «Усны шастир», «Шорооны шастир», Номч хамба Агваанпунцагийн «Галын шастир», «Төмрийн шастир», «Эрдэнийн шастир», Жилсүр Лувсанжамбын «Хийн шастир», «Нарны шастир», «Сарны шастир», Монголын Нанзад аграмбын «Шорооны шастир», Ишданзан-ванжил «Галын шастир», зэрэг сургаалын зохиол шил шилээ даран гарчээ.

Монгол зохиолчдын төвөд хэлээр бичсэн сургаалын шүлгийг зөвхөн монголын тухайд салган авч үзэх биш, ийм сургаалыг үүсэж хөгжихөд нөлөө дуурайл болсон Энэтхэг, Төвөд зэрэг улс үндэстний сургаалын шүлэгтэй холбон судлах хэрэгтэй юм [Хүрэлбаатар 1987: 145]. Хэдийгээр энэ төрлийн хос ёсны сургаал Төвөдөөс уламжилсан боловч монгол эрдэмтэн лам нар махбодын дутууг нөхөн гүйцээсэн шастирууд туурвиж байжээ.

Энэхүү өгүүлэлдээ төвөд, монгол хоёр өөр хүний зохиосон «Галын шастир»-ыг харьцуулан ажигласнаа толилуулахаар зорилоо. Энэ нь:

1. Монгол эрдэмтэн лам Ишданзанванжил (1854–1907)-ын «галын шастир»
2. Төвөд эрдэмтэн Номч хамба Агваанпунцаг (1882–1954)-ийн «галын шастир»

Ишданзанванжилын намтар бүтээлийн товч ба «галын шастир»

Данзанванжил 1854 онд Цахарын Хөвөөт цагаан хошууны Дүүрэн овоо хэмээх газар амбан Намжилдоржийн хүү болон мэндэлжээ. Долоон наснаас арван таван нас хүртлээ «Гүнгийн зуу» сүмдээ монгол төвөд хэл бичиг сурч, хориод насандаа Амдогийн Гүмбүм хийдэд очиж хэдэн жилийн турш шашны гүн ухаан, эмийн ном үзсэн бөгөөд Төвөдийн «Эмийн дөрвөн үндэс»-ийн эмийн жорыг шинэчилж, монгол газрын хүмүүсийн бие махбодод нийцүүлэн «Сувдын унжлага», «Шүрийн унжлага», «Эрдэнийн унжлага» хэмээх гурван зүйл шинэ жорыг төвөд хэлээр зохиосон эмчилгээ хийж байсан гэдэг. Дөч гаруй насандаа Халхын их хүрээнд ирж хэдэн жил сууж байгаад 1903 онд буцаж Шилийн голын Зүүн Сөнөдөд очиж, 1905 онд Шилийн голоос сүмдээ буцаж очоод 1907 онд тавин дөрвөн насандаа таалал барьсан байна [МУЗТ 1968: 118; Алтангэрэл 1967: 89].

Тэрбээр зохиол бүтээлээ төвөд монгол хэлээр туурвисан бөгөөд хоёр боть сүмбүм нь эдүгээ ч бүрнээр олон нийтийн хүртээл болоогүй байна [Төвөд хэлт

сургаалын … 2023: 195]. Төвөд хэлээр нэгэн боть зохиол буй гэдэг. Зохиолууд нь хэвлэгдээгүй, гар бичмэлээр уламжилж иржээ. Монгол хэлээр бичсэн алдартай сургаалын зохиол нь «Гүнгийн зуугийн гэгээний алтан сургаал» юм.

Ишданзанванжилын намтар бүтээлийн талаар Монгол болон Өвөр Монголын эрдэмтэн судлаач нар нэлээд судалсан байна. Түүний шүлгүүдийг судалгааны эргэлтэд оруулах, гүн ухаан, нийгмийн үзэл санаа, утга уран сайхны онцлогийг нь судлах, гар бичмэл эхүүдийг хэвлүүлэх зэргээр анхаарч иржээ.

Уг шастирын төвөд эх нь Монголын Үндэсний Номын Сангийн төвөд номын хөмрөгт хадгалагдаж байна. Бүтэн нэр нь **мо**: «*Сайн номлол галын шастир хоёр ёсны төгс гэрэлт зуун наран*» **тө**: legs par bshad pa me'i bstan bcos lugs gnyis tsha zer brgya ldan zhes bya ba bzhugs so.

Монгол эрдэмтэн судлаачдаас Ч. Алтангэрэл орчуулан 1967 онд хэвлүүлсэн [Алтангэрэл 1967: 90–105]. И. Дэмбэрэл 1998 онд орчуулж хэвлүүлжээ [Дэмбэрэл 1998: 2–34]. Х. Бираасүрэн 2023 онд Ч. Алтангэрэлийн орчуулгыг төвөд эхтэй нь харгуулан тухайн үеийн үзэл суртлын нөлөөнөөс болж орхисон байх магадлалтай цөөн мөртийг орчуулан нэмж оруулсан байна [Төвөд хэлт сургаалын … 2023: 195–282].

Он цаг, бүтэц, агуулга, утга санаа

Ишданзанванжил «галын шастир»-аа зохиосон он цагийг төгсгөлийн үгэнд дурдсангүй, барагцаалбал 1880-аад оноос хойш 1907 оноос өмнө бичсэн байх учиртай. Зохиолоо дөрвөн мөртөөр шүлэглэн бичсэн бөгөөд үүний эхний хоёр мөрт ертөнцийн жам ёсыг өгүүлээд, сүүлийн хоёр мөрт «гал» болон галтай холбоотой зүйлийн мөн чанарын илэрхийллээр зүйрлэжээ. Жишээлбэл:

Их чөлөөт хүний биеэр
Ихсийн газарт хүрч болно
Идэт гал усны хүчээр
Идээ ундааг бэлэн болгоно.

Үүний эхний хоёр мөр нь «их чөлөөт хүмүүн» буюу «номын багш»-ийн ач буяныг өгүүлсэн бол сүүлийн хоёр мөрт «гал»-ын унд хоолыг буцалгаж болгон, хүнд ашиг тусаа үзүүлдэг үйлдлээр нь адилтгасан байна.

Зохиолын бүтэц нь нэг бадаг мөргөлийн шүлэг, хоёр дахь бадаг адистид соёрхохыг гуйсан, гурав дахь бадаг сургаал бичихээ тангарагласан бөгөөд ес есөн бадгаар хэсэгчлэн нэрлэсэн арван хоёр хэсэг буюу 108 бадаг, төгсгөх шүлэг хоёр бадаг, нийт 113 бадаг төгсгөлийн үгээс бүрдэнэ. 1967 онд хэвлэгдсэн орчуулгад 7, 9, 5, 38, 41, 43, 44, 66, 98, 104 дэх бадгуудын эхний хоёр, 56 дахь бадгийн сүүлийн хоёр мөрүүдийг орчуулаагүй үлдээснээс Х. Бираасүрэн эмхэтгэхдээ 56, 98, 104 дэх бадгуудад орхисон мөрүүдээс бусдыг орчуулж нэмэн оруулжээ. Ч. Алтангэрэл орчуулахдаа 39, 68 дахь бадгийн эхний хоёр мөрийг сүүлийн хоёр мөртэй сольж тавьсан буй. Уг арван хоёр хэсгийн нэр нь:

1. Багшийг ёсчлон шүтэхийг сургасан есөн шүлэг.

2. Сайн шүтээнийг (хүний биеийг) олохуйяа бэрх ёсны онохыг сургасан есөн шүлэг.

3. Мөнх бусыг сануулахаар сургасан есөн шүлэг.

4. Эцгийн орныг тэвчихээр сургасан есөн шүлэг.

5. Маш гарахуйд сургасан есөн шүлэг.

6. Мэргэжил эрдэм сургахыг сургасан есөн шүлэг.

7. Судар тарнийг бясалган авахыг аль чадахаар сайтар шамдахыг сургасан есөн шүлэг.

8. Оюун санааг бодь сэтгэлээр эзлүүлэхээр сургасан есөн шүлэг.

9. Үйл үрд итгэмжлэхийг сургасан есөн шүлэг.

10. Орчлонд шунахыг буцаасаар сургасан есөн шүлэг.

11. Муу заяанд одохоос сэрэмжлэхийг сургасан есөн шүлэг.

12. Чөлөө учралыг утга төгөлдөр зэрэгт болгохоор сургасан есөн шүлэг юм.

Зохиогч тэрхүү хэсэг тус бүрт нэрийн утгыг тодотгосон утга агуулгыг шүлэглэсэн байна. Жишээлбэл,

Нэг дэх хэсэгт:

*Ачит **багш**ийн алтан сургаал*
Аливаа дээдээс хавьгүй илүү
*Асах **гал**ын халуун илч нь*
Аливаа халуунаас үлэмж илүү

Гурав дахь хэсэгт:

Мөнх бусыг ярих нь олон ч
Мөнх сэрэмжлэх нь өдрийн од шиг
Гал түймэр алдахаас айвал
Гагцхүү урьдаас сэрэмж хэрэгтэй

Гэх зэргээр нэрийн утгад шүтэлцүүлжээ.

Уг шастираа бичихдээ *«me*-гал» хэмээх үгийг 112 удаа хэрэглэж, 16 бадагт тус бүр хоёр, 2 бадагт гурван удаа давтсан бөгөөд чухамхүү гэрэлтүүлэн гийгүүлэх, ээн дулаацуулах, түлж шатаах, сайн муу аливааг даран устгах эерэг сөрөг олон зүйл үйлдэл, шинжид нь хамаа бүхий дараах үгсийг багтаан бичжээ. Үүнд: нарны гэрэл-nyi ‘od-2, зул-me sgron-1, sgron me-3, галт од-me skar-1, тулга, зуух-me thab-3, галын оч-me dpal-1, галын нурам-me mur -1, хэт цахиур-me cha-3, зул-mar me-7, галын дөл-me lce-11, галын тэнгэр-me lha-3, галын илч-me drod-1, буу-me mda’-5, галт шил-me shel-4, нүүрсний цог-sol me-6, галт бумба- me bum-1, галт төөнө-me btsa’-2, галын тахилга- me mchod-1, шатаах-bsreg-2, улайссан төмөр-sregs lcags-1, дарь-me rdzas-1, галт сум-me mde’u-1.

Гал бол одон болон хар зурхайн таван махбодын нэг бөгөөд хар зурхайн таван махбодын онолоор юмс үзэгдэл эх, хүү, нөхөр, дайсны харьцаанд оршдог хэмээн номлодог. Уламжлалт анагаах ухаанд таван цул, зургаан сав эрхтэн мөн адил харьцаанд оршдог. Цул эрхтнээс зүрх, сав эрхтэнээс гэдэс гал махбодтой. Гал махбод бол халуун чанартай, дүрс, дуу, хүрэлцэхүйн гурван эрдэм төгсөж, боловсруулах, хайлуулах, шатаах үйлдэлтэй (Чоймаа). Чингээд галын мөн чанар, махбодын шинж, үйлдэл шастирт хэрхэн туссаныг эерэг, сөрөг үнэлэмжээр авч үзье.

Эерэг үнэлэмжийн үүднээс:

Ач тус: 12, 30, 45, 46, 50, 58, 64, 67, 73, 74, 81, 104 (12).

Өөдөө бадран асах: 35 (1).

Ариусгах: 51, 111 (2).

Боловсруулах: 6, 105, 18, 33, 44, 48, 52, 62, 80 (9).

Халуун, дулаацуулах: 2, 5, 9, 16, 34, 41, 76, 93 (8).

Хайлуулан хувиргаж ашиглах: 4, 10, 14, 55, 82 (5).

Шатаах, хатаах: 1, 3, 11, 19, 31, 75, 101 (7).

Ойр орчныг гийгүүлэх: 8, 68, 79, 113 (4).

Анагаан эмчлэх: 21, 61 (2).

Сөрөг үнэлэмжийн үүднээс:

Түлэх шатаах, устган сүйтгэх, хатаах: 11, 17, 23, 26, 29, 32, 38, 43, 47, 63, 66, 70, 71, 78, 86, 87, 88, 90, 92, 96, 97, 98, 99, 101 (24).

Унтрах бөхөх: 20, 22, 26, 27, 37, 63 (6).

Тус хэрэг болохгүй: 28, 54, 59 (3).

Үүнээс үзэхэд зохиолд галын эерэг үнэлэмж илүүтэй туссан бөгөөд ерөөс галын эерэг шинж чанар харьцангуй давамгай, ач тус ихтэй, ашигтай үйлдэл олонтой нь харагдаж байна. Шатаах, хатаах үйдлийн тухайд эерэг, сөрөг тал аль аль нь байх боловч сөрөг үйлдэл нэн илүүтэйн зэрэгцээ тохироо бүрдээгүй, орчин нөхцөл, их багын хэмжээ тааараагүй тохиолдолд гал тус хэрэг болохгүй ажээ. Түүнчлэн учир шалтгааны холбоог илэрхийлсэн зүйрлэл багагүй хувийг эзэлж байна. Үүнд: 39, 49, 60, 65, 72, 77, 83, 84, 85, 93, 94, 95, 100, 103, 105, 106, 107, 108, 109, 110 дугаар бадгууд.

Хоосон чанарыг гал болон зулын бөхөж унтрах, үнс нурам болж үлдэхээр зүйрлэжээ.

Хээээ үхэх нотолгоо байхгүй ч

Хэдэн жилийн амьдралга бэлдэнэ

Зуун мянган зул бадравч

Зуурмын өчүүхэн салхинд бөхнө

хэмээн мөнх бус энэ амьдралд хэтийдсэн зүйл хурааж хадгалахыг шүүмжилсэн санаагаа зул хэчнээн олон байлаа ч жаахан салхинд унтрахтай жишин адилтгасан байна. Зохиолыг бүхэлд нь ажиглахад монгол нүүдлийн ахуйн зураглал буухуйц мөр бадгууд тохиолдоно. Тухайлбал,

Хотол чуулган эд малтай ч

Хорт зудад үрэгдэх нь олон (37) гэснээс эрс тэс уур амьсгалтай Монгол орны хатуу ширүүн өвлийн ерөнхий байдал санаанд тодорно.

Цай хоол буцалгах гал

Цааш дэндвэл гэрийг ч шатаана (92) хэмээсэн нь монгол хүнд бол тулганд ил задгай гал түлдэг байсан нүүдлийн амьдрал төсөөлөгдөх юм.

Ийнхүү Ишданзанванжил бээр ертөнцийн жам ёсыг галаар үлгэрлэн «гал» хэмээгчийн, өмнө дурдсан олон шинж, үйдэлтэй жишиж «хүмүүний бие нь олдохуйяа бэрх тул энэ насандаа орчлонгийн жам ёсыг таньж, сайн багшийг шүтэн, төрсөн гэртээ эргэцэлгүй, судар тарнийг бясалгаж, ном эрдмийг сурч, орчлонд шунах сэтгэлээ ялан, бодь мөрийг чухалчилж, муу заяанд одохоос сэрэмжлэн, мөнх бусын энэ орчлонгоос гэтлэн нирвааны хутгийг олохыг хичээх»-ийг ер нийтэд хандан сургамжилжээ.

Дурдан буй зохиол бол хос ёсны сургаал бөгөөд нэрээс нь харахад тодорхой байна. Хос ёсны сургаал хэмээх нь хэн бүхний мэдэхээр ертөнцийн ёс, номын ёс хоёрыг шүтэн барилдуулж, авах гээхийн ухаанаар тунгааж, улс гүрнийг залан засах төрийн бодлого, түмэн олны аж төрөх хэв заншилдаа баримтлах гол зарчмыг

ухааруулсан номлолын цогц юм [Чоймаа 2017: 198]. Энэхүү ертөнцийн ёсны сургаалд ертөнцдөө эв зүйтэй, зөв шулуун амьдрахыг голлон сургамжилдаг ажээ [Хүрэлбаатар 1987: 172–173, 194–195].

Номч хамба Агваанпунцагийн намтар бүтээлийн товч ба «галын шастир»

Номч хамба Агваанпунцаг бурханы шашны гаадамбын урсгалын төлөөлөгч бөгөөд Монголд намтар түүхийг нь тодорхой судлаагүй байна. Сахилын нэр болох Ершон ханчин номун хан Агваанлувсанданзанжамц нэрээр илүүтэй алдаршжээ. Дамбашавранпунцоглин (dam pa sha sbrang phun tshogs chos gling) хэмээх хийдтэй намтар түүх нь холбогдоно. Түүний сүмбүмийн зохиолууд дахь төгсгөлийн үгээс үзвэл Хөх нуур нутгийн хүн бололтой [g.Yer gshong mkhan chen … El. resource]. Түүний туурвисан «галын шастир»-ын эх 2006 онд Хөх нуурт хэвлэгджээ [bsTan bcos kyi skor 2006: 161–181]. **Төө:** dam pa chos lugs kyi me'i bstan bcos thar lam gsal ba'i sgron me zhes bya ba bzhugs so. **Мо:** «Дээд номын ёсны галын шастир тонилохуйн мөрийг тодруулагч зул хэмээх оршвой».

Зохиолоо тодорхой зүйл хэсэгт хуваагаагүй, мөргөлийн шүлэг нэг бадаг, гол утга агуулгыг шүлэглэсэн 67 бадаг, ерөөлийн шүлэг 2 бадаг, нийт 70 бадаг болон төгсгөлийн үг бүхий шастир юм. Төгсөлийн үгэндээ шороон туулай жил туурвиснаа дурдсан нь 1939 он болно. Дөрвөн мөртийн эхний хоёрыг гал болон галын хамаа бүхий зүйлээр өгүүлээд сүүлийн хоёр мөрт хорвоогийн жам ёс, дүр байдал, бурханы номын холбоотой утга агуулгыг гаргасан байна. Шастираа бичихдээ галыг «зул-mar me-30, зул-sgron me-26, шар тос-mar khu-1, гал-me-7, зулын гол-sdong bu-1, зулын гэрэл-snang gsal 'od-1, зул төгөлдөр-snang gsal ldan-1, зул эрдэнийн гэрэл-snang gsal rin chen 'od-1, гэрэле'od-1, зул-snang byed-1, гэгээн саруул нүд- snang gsal mig-1» зэрэг үгсээр төлөөлүүлснээс «зул»-ыг голчлон дүрсэлжээ.

Агуулгыг ерөнхийд нь задлан ажиглавал:

– Номын багшийг шүтэх
– Чөлөө учралт хүмүүний биеийг олох
– Бат сүсэг бишрэлтэй байх
– Бодь сэтгэлийг үүсгэх
– Мөнх бус, хоосон чанаряг онох
– Үйлийн үрийн учир шалтгаан
– Сурч судлахыг чухалчилж, авах гээхийн ухаанд мэргэжих
– Номын явдлыг эрхэмлэх
– Бясалгал самадид шамдах
– Номын ач тус, адистидыг дурдан санах
– Бурханыг шүтэх

тухайт утга агуулгыг товч тодорхой номлосон бөгөөд «зул»-ын мөн чанар буюу аливаа үзэгдлийг гэрэлтүүлэн тодруулж, хамаг бүхэнд баяр баясгаланг түгээх" тэрхүү эерэг үйлдэлд нь шүтэн, хорвоогийн жам ёсыг үлгэрлэн жишсэн байна. Ер «бурханы сургаалыг даган, буян номын үйлд зорихыг» дурдан сануулсан ажээ.

Энэхүү сургаалыг хос буюу хоёр ёсных хэмээн тодотгосонгүй, гагцхүү номын ёсыг чухалчилсан нь «дээдийн номын ёсны шастир, тонилохуйн мөрийг тодруулагч зул» хэмээх нэрээсээ тов тодорхой бөгөөд номын зул бадамлан асаж, хамаг амьтныг мунхгийн харанхуйгаас сэрээн бурханы гэрлийг түгээх болтугай гэсэн ерөөлөөр

төгсөж байгаа нь багшид шүтэж, бурханы номын ач тус, адис жинлавыг санаж, цаг ямагт номд шамдан бурханд сүслэхийг уриалсан агуулгатай байна. Жишээлбэл:

3. Эрдэнэт зулыг шүтэн үйлдвээс
Харанхуй арилаад үзэгдэл тодормуй
Тэр мэт дээд багшаа шүтвээс
Мунхгийн харанхуй арилаад билиг сайтар тодормуй

Ингээд уг зохиолд галын буюу зулын мөн чанар, үйлдлийг хэрхэн тусгасныг авч үзэцгээе.

Эерэг үнэлэмжийн үүднээс:

Мунхгийг арилгах 1, 3, 40 (3).

Гэрэл түгэх 2, 8, 13, 14, 20, 21, 27, 38, 41, 44, 46, 51, 52, 59, 62, 63 (17).

Үзэгдэл тодрох 3, 23, 30, 34, 43, 47, 49, 58, 65, 67 (10).

Харанхуйг арилгах 4, 5, 15, 24, 25, 29, 31, 39, 42, 66 (10).

Гэрэлтүүлж баясгах 6, 16, 22, 28, 36, 37, 55, 61, 64 (9).

Ариун 35 (1).

Дээш бадрах 54 (1).

Сөрөг үнэлэмжийн үүднээс:

Шатаах 18, 19, 26, 33, 60 (5).

Зул бөхөх - амь нас 10, 32, 48, 53 (4).

Агваанпунцаг галыг «зул»-аар төлөөлүүлсний хувьд гэрлийг түгээж, харанхуйг арилган, юмс үзэгдлийг тодруулж, хотлыг гэрэл гэгээгээрээ баясгах эерэг үнэлэлмж бүхий мөн чанар, үйдлийг зонхилон тусгасны зэрэгцээ ариусгах, дээш бадрах шинжийг нь ч орхигдуулаагүй ажээ. Ялангуяа мунхгийг харанхуйг арилган дарах бэлгэдлийн санааг ихэд чухалчилсан бөгөөд сөрөг үнэлэмжийн талаас үзвэл шатаах түлэх, унтарч бөхөх үйлдлийг илэрхийлээд амь нас мөнх бус, хэврэг хэмээх санааг зул бөхөхтэй адилтгахын сацуу хоосон чанар 12, 56, 57 (3), учир шалтгааны холбоо хамаарал 1, 11, 45, 50 (4)-ыг мөн илэрхийлсэн байна. Жишээлбэл:

6. Гэгээн гэрэл төгс болбоос шөнө ч
Хүмүүн нүгүүд баясан үйл үйлдэх
Дээд итгэл лүгээ сэлтийн үес
Номчлон явахад баясан үйлдэх
24. Шөнийн харанхуйг арилгахыг хүсэгч
Зулын гэрлийг шүтэх нь сайн арга
Мунхгийн харанхуйг арилгахыг хүсэгч
Мөн чанарыг онох билгийг эрэгтүн.
17. Мунхгийн хяруунд дарагдсан төрөлхтөнүүд
Магад үзэсгэлэнт дүрсэд шунаснаар доройтмуй
Машид харанхуйд оршигч эрвээхэй
Мунхарч зул үзээд шатахыг үзэгтүн.

Дурдан буй бадгуудад зулын гэрэлтүүлэх үйлдэл, түүнд хүмүүс баясан шүтэхтэй адил мунхгийн харанхуйгаас гэтлэхийн тул ном эрдэмд баясан шамдаж билиг ухааныг олоход дуршихыг дурдан сануулжээ. Ер гэгээрэлд хүрэх зам мөрийг онох эрдэм ухаанд суралцахыг дээдлэн сургасан хэмээн үзэж болно.

Хоёр зохиолыг харьцуулан судлахад дараах дөрвөн мөрөөс өөр адил төстэй мөр бадаг үгүй байна.

Ишданзанванжилын «Галын шастир»	*Номч хамбын «Галын шастир»*
Галаваар харанхуй байсан нүх Ганцхан зулаар ч гийгэх цагтай	Зулыг болор нүхэнд тавиваас Тэрхүү жижиг нүхэнд буй бүхэн үзэгдмүй
Дэнгийн гэрэлд шунан эргэлдсэн Дэрэвгэр эрвээхэй үхэлд учирна	Машид харанхуйд оршигч эрвээхэй Мунхарч зул үзээд шатахыг үзэгтүн

Дүгнэлт

1. Зохиогдсон цаг хугацааны хувьд Ишданзанванжилын “галын шастир” түрүү үед хамаарна.

2. Ишданзанванжилын сургаал хос ёсных бөгөөд зохиомж нь эхний хоёр мөртөөр үндсэн санаагаа илэрхийлээд сүүлийн хоёр мөртөд адилтгал зүйрлэлээ гал болон галтай ойролцоо зүйлээр төлөөлүүлэн бичжээ.

Номч хамба Агваанпунцагийн сургаал бурханы номыг чухалчилсан бөгөөд бурхан номтой ойр «зул»-аар галыг төлөөлүүлжээ. Зохиомж нь гол төлөв эхний хоёр мөрт зул болон холбоо хамаарал бүхий зүйлийг өгүүлээд сүүлийн хоёр мөрт үндсэн санаагаа түүндээ шүтэлцүүлэн илэрхийлсэн байна.

Уг хоёр зохиолын нэрээс ерөнхий агуулга, үзэл санааны чиг тодорхой харагдаж буй.

3. Ишданзанванжил сургаалаа хар шар нийтэд зориулсан, өргөн утга агуулгатай, монгол ахуй тусгасан байдал ажиглагдаж байгаа бол Агваанпунцаг гагцхүү шашин номын утга учрыг ухаарах, суралцахад шамдахыг сургаснаараа лам хуврагуудад зориулсан шинжтэй.

4. Энэхүү сургаалуудын тухайд нэг нэгээсээ санаа авсан гэж хэлэхээр зүйл үгүй шиг байна. Төстэй дөрвөн мөр шүлэг буй нь хэн бүхний мэдэхүйц утга санаа ажээ.

Литература

bsTan bcos kyi skor. – mTsho sngon mi rigs dpe skrun khang, 2006.

g.Yer gshong mkhan chen no mon han ngag dbang blo bzang bstan 'dzin rgya mtsho [Electronic resource]. – Access mode: https://www.tbrc.org/#!rid=P228.

Ngag dbang blo bzang bstan ‘dzin rgya mtsho. Khyab bdag rdo rje ‘chang bka’ drin mtshungs med g.yer gshong mkhan chen chos kyi rgyal po’i bka’ ‘bum phyogs bsgrigs thar ‘dod re skong bsam ‘phel yid bzhin dbang gi rgyal po / Collective works of a Geluk master Yer shong Ngawang Lobzang Tenzin Gyatso volume 1. – Lankru’u: Kan su’i mi rigs dpe skrun khang, 2007.

Алтангэрэл Ч. Монгол зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл / Ч. Алтангэрэл. – Улаанбаатар: Шинжлэх ухааны академийн хэвлэлр, 1967.

Дамдинсүрэн Ц. Монголын уран зохиолын тойм. Гуравдугаар дэвтэр / Ц. Дамдинсүрэн. – Улаанбаатар: Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо, 1968.

Дамдинсүрэн Ц. Монголын уран зохиолын тойм, Хоёрдугаар дэвтэр / Ц. Дамдинсүрэн, Д. Цэнд. – Улаанбаатар: Шинжлэх ухааны академийн хэвлэл, 1976.

Дэмбэрэл И. (орч) Дөрвөн махбодын шашдир / И. Дэмбэрэл. – Улаанбаатар, 1998.

Төвөд хэлт сургаалын зохиолын бичвэр зүйн судалгаа-1. ШУА, Хэл зохиолын хүрээлэн. – Улаанбаатар, 2023.

Хүрэлбаатар Л. Академич Цэндийн Дамдинсүрэн, Дурсгалын түүвэр / Л. Хүрэлбаатар. – Улаанбаатар, 2008.

Хүрэлбаатар Л. Монголын уран зохиолын дээж, Найман боть. Боть I / Л. Хүрэлбаатар. – Улаанбаатар, 1995.

Хүрэлбаатар Л. Сонгодог уламжлал монгол яруу найраг / Л. Хүрэлбаатар. – Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1989.

Хүрэлбаатар Л. Энэтхэг Төвөд Монголын сургаалын зохиолын хэлхээ холбоо. Хэл зохиол судлал, XVIII боть / Л. Хүрэлбаатар. – 1987. – 145–270.

Цэрэнсодном Д. Монгол уран зохиол, XIII–XX зууны эхэн / Д. Цэрэнсодном. – Улаанбаатар: БНМАУ-ын Ардын Боловсролын Яамны Сурах бичиг сэтгүүлийн нэгдсэн редакцийн газар, 1987.

Чоймаа Ш. Хос ёсны сургаалаар төрөө засаж ирсэн уламжлал. МУИС, профессорын эрдмийн өв. Монгол хэл бичиг, соёл судлал / Ш. Чоймаа. – Улаанбаатар, 2017.

References

bsTan bcos kyi skor. – mTsho sngon mi rigs dpe skrun khang, 2006.

g.Yer gshong mkhan chen no mon han ngag dbang blo bzang bstan \'dzin rgya mtsho [Electronic resource]. – Access mode: https://www.tbrc.org/#!rid=P228.

Ngag dbang blo bzang bstan ‘dzin rgya mtsho. Khyab bdag rdo rje ‘chang bka’ drin mtshungs med g.yer gshong mkhan chen chos kyi rgyal po’i bka’ ‘bum phyogs bsgrigs thar ‘dod re skong bsam ‘phel yid bzhin dbang gi rgyal po / Collective works of a Geluk master Yer shong Ngawang Lobzang Tenzin Gyatso volume 1. – Lankru’u: Kan su’i mi rigs dpe skrun khang, 2007.

Altangerel Ch. Mongol zohiolchdyn tөvdөөr bichsen bүteel / Ch. Altangerel. – Ulaanbaatar: Shinzhlekh uhaany akademijn hevlelp, 1967.

Damdinsүren C. Mongolyn uran zohiolyn tojm. Guravdugaar devter / C. Damdinsүren. – Ulaanbaatar: Ulsyn hevlelijn hereg erhlekh horoo, 1968.

Damdinsүren C. Mongolyn uran zohiolyn tojm, Hoyordugaar devter / C. Damdinsүren, D. Cend. – Ulaanbaatar: Shinzhlekh uhaany akademijn hevlel, 1976.

Demberel I. (orch) Dөrvөn mahbodyn shashdir / I. Demberel. – Ulaanbaatar, 1998.

Tөvөd helt surgaalyn zohiolyn bichver zүjn sudalgaa-1. ShUA, Hel zohiolyn hүreelen. – Ulaanbaatar, 2023.

Hүrelbaatar L. Akademich Cendijn Damdinsүren, Dursgalyn tүүver / L. Hүrelbaatar. – Ulaanbaatar, 2008.

Hүrelbaatar L. Mongolyn uran zohiolyn deezh, Najman bot'. Bot' I / L. Hүrel-baatar. – Ub hot., 1995.

Hүrelbaatar L. Songodog ulamzhlal mongol yaruu najrag / L. Hүrelbaatar. – Ulaanbaatar: Ulsyn hevlelijn gazar, 1989.

Hүrelbaatar L. Enetheg Tөvөd Mongolyn surgaalyn zohiolyn helhee holboo. Hel zohiol sudlal, XVIII bot' / L. Hүrelbaatar. – 1987. – 145–270.

Cerensodnom D. Mongol uran zohiol, XIII–XX zuuny ekhen / D. Cerensodnom. – Ulaanbaatar: BNMAU-yn Ardyn Bolovsrolyn Yaamny Surah bichig setgүүlijn negdsen redakcijn gazar, 1987.

Chojmaa Sh. Hos yosny surgaalaar tөrөө zasazh irsen ulamzhlal. MUIS, professoryn erdmijn өv. Mongol hel bichig, soyol sudlal / Sh. Chojmaa. – Ulaanbaatar, 2017.